

Цахим (е-) баримтын хэрэгжилтийг сайжруулах нь

Improving the implementation of the e-document

Л. Хишигбаяр¹, Д. Лхагвасүрэн²

Хураангуй

Монгол улс 1998 оноос НӨАТ-ыг нэвтрүүлж, 2016 оны 1-р сарын 1-нээс шинэчлэн найруулсан НӨАТ-ын хуулийг хэрэгжүүлж байна. Шинэчилсэн найруулга нь татвар төлөгчийн оролцоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, татвар төлөгчдийг урамшуулах, бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах замаар бизнест ээлтэй, тэгш шударга өрсөлдөх орчныг бий болгох, далд эдийн засгийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэгдсэн. Шинэчилсэн найруулга хэрэгжсэнээр 2016 оны НӨАТ-ын орлого өмнөх оныхоос 70 тэрбум төгрөгөөр өссөн эерэг үзүүлэлттэй байгаа боловч зарим худалдааны төв, зах, дэлгүүрийг бүрэн нэгдсэн системд хамруулж чадаагүйгээс хэрэглэгчдэд нэгдсэн дугаар бүхий цахим төлбөрийн баримт (е-баримт) хэвлэж өгдөггүй зөрчил гарсаар байгаа нь татварын тэгш шударга зарчмыг алдагдуулж, хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. НӨАТ-ын хуулийн хэрэгжилт сул байгаа захуудаас “100 айл” барилгын материалын захыг сонгон 145 бизнес эрхлэгч, 292 үйлчлүүлэгчээс асуулгын аргаар судалгаа авах замаар е-баримтын хэрэгжилтийг судлахад хэрэглэгчдийн 59% нь худалдан авалтандаа е-баримт огт авдаггүй гэсэн үр дүн гарсан. Мөн бизнес эрхлэгчид худалдан авалтын үнийн дүнгээс хамаарч е-баримтыг ялгаатай байдлаар олгодог бөгөөд НӨАТ-ын талаар хангалттай мэдлэгтэй бизнес эрхлэгчдийн е-баримт олголтын түвшин сайн байна гэсэн үр дүн гарсан.

Түлхүүр үгс: е-баримт, хуулийн хэрэгжилт, цахим систем

Abstract

In Mongolia, the VAT has been implemented initially since 1998, the last draft which has been executing as 2016.01.01. The revised law is designed to improve the legal environment for creating a business-friendly and equitable competitive environment through the enforcement of tax laws, encouraging taxpayers and improving accounting and control systems. With the revised law, the revenue of the 2016 VAT increased by 70 billion MNT compared to the previous year, but as a result of not enough execution to printing process of e-documentation there is negatively affect the implementation of the law and disrupt the fairness. Our goal is to determine Mongolian current situation of implementation of the e-document. This survey has been involved around 145 entities and 292 customers of “100 ail” market. The findings of the study 59% of consumers did not receive any e-document from their purchases. In addition, issue of e-document has been depending from purchase price. Entrepreneurs with sufficient VAT knowledge give e-document more than others.

Keywords: e-document, enforcement, e-system

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн багш, МНБ, ТИНБ
E-mail: khishgee_8888@yahoo.com

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн багш, МНБ
E-mail: lkhagva0125@yahoo.com

Танилцуулга

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) нь эцсийн хэрэглээнд ногддог бөгөөд бизнесийн үйл ажиллагаанд дарамт учруулахгүйгээр хэрэглэгчийн хэрэглээгээр дамжин төлөгддөг шууд бус татвар юм³. Мөн улс орны төсвийн орлогыг бүрдүүлэх гол эх үүсвэр төдийгүй татварын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэхэд чухал ач холбогдолтой. НӨАТ нь одоогоор дэлхийн 160 гаруй оронд нэвтэрч, жил бүр дунджаар татварын орлогын 27 хувь⁴ буюу дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 5 орчим хувьтай тэнцэх хэмжээний орлогыг бүрдүүлж байна. Монгол улс 1998 оны 7 сараас НӨАТ-ыг нэвтрүүлж, 2016 оны 1 сарын 1-нээс эхлэн шинэчлэн найруулсан НӨАТ-ын хуулийг хэрэгжүүлж байна. Шинэчилсэн хууль нь хуулийн хэрэгжилтэд татвар төлөгчдийн оролцоотойгоор хяналт тавих, татвар төлөгчдийг урамшуулах, бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах замаар бизнест ээлтэй, тэгш шударга өрсөлдөх орчныг бий болгох, далд эдийн засгийг бууруулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн. Хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор татвар төлөгч болон татварын албадын хооронд тайлан илгээх, баримтаа шивэхтэй холбоотой программ гацах, аж ахуйн нэгж баримтаа илгээхгүй байх, үнийн дүн зөрөх гэх мэт асуудлууд үүссэн ч 2016 оны НӨАТ-ын орлого өмнөх оныхоос 70 тэрбум төгрөгөөр өссөн эерэг үр дүн гарсан. Хууль мөрдөгдөж эхлээд 2 жилийн хугацаа өнгөрсөн ч бүх худалдааны төв, зах, дэлгүүрийг бүрэн нэгдсэн системд хамруулж чадаагүйгээс хэрэглэгчдэд нэгдсэн дугаар бүхий төлбөрийн баримт (е-баримт) хэвлэж

өгдөггүй зөрчил их байгаа нь татварын тэгш шударга зарчмыг алдагдуулж, хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Иймээс бид энэхүү судалгаагаараа НӨАТ-ын хуулийн хэрэгжилт сул байгаа “100 айл” барилгын материалын захын е-баримтын хэрэгжилтийн өнөөгийн байдлыг судалж, е-баримтын хэрэгжилтийг идэвхжүүлэх шийдлийг тодорхойлохыг зорьсон. Судалгаанд 100 айл барилгын материалын захын 145 бизнес эрхлэгчээс ярилцлагын аргаар чанарын, 292 үйлчлүүлэгчээс анкетын аргаар тоон судалгаануудыг тус тус авсан.

Сэдвийн судлагдсан байдал

НӨАТ-ыг нэвтрүүлсэн туршлагаас харахад улс орон бүр өөрийн онцлогт тохируулан тодорхой босготой, босгогүй нэг хувь хэмжээтэй байхаас гадна буцаалт хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг өөрийн орны онцлогт тохируулан шийдвэрлэдэг байна. НӨАТ-тай холбоотой статистик тоо мэдээллүүдийг ашиглан түүний эерэг сөрөг талуудыг тодорхойлох, холбогдох хууль тогтоомж, хэрэгжүүлж буй арга зарчмуудад дүгнэлт хийх, тэдгээрийг улам боловсронгуй болгох стратеги боловсруулах чиглэлээр багагүй судалгааны ажлууд хийгдсээр байна.

Harrison нар (2005) НӨАТ-ын буцаалт нь ямар хүчин зүйлсээс хамаарч байгаа талаар дэлгэрэнгүй судалсан байна. Энэхүү судалгааны үр дүнгээр буцаалтын хувь хэмжээ нь эдийн засгийн үндсэн шинж, татварын системийн хэлбэр, татвар төлөгчийн зан төлөв, татварын удирдлагын систем зэрэг хүчин зүйлсээс хамааралтай болохыг тогтоожээ.

Keen нар (2010) 143 орны 25 жилийн

³ Алтанзаяа, Г. (2016), хуудас 157

⁴ http://gst.customs.gov.my/en/gst/Pages/gst_ci.aspx

мэдээлэлд үндэслэн НӨАТ нэвтрүүлэх нь улсын эдийн засаг, татварын тогтолцоонд эерэгээр нөлөөлдөг гэж үзсэн.

Ебеке нар (2011) 1980-2008 оны хоорондох хөгжиж буй 103 орны хувьд НӨАТ-ын хэрэгжилт ямар байгааг судалсан байна. Энэхүү судалгааны үр дүнгээр НӨАТ нь тогтворгүй, бага хэмжээний татварын орлого бий болгодог гэж үзсэн. Судлаачид НӨАТ-ын систем ашигладаг улс орны татварын орлого нь НӨАТ ашигладаггүй улс орныг бодвол 40-50% бага байгааг судалж гаргасан бөгөөд үүний шалтгаан нь эдийн засгийн хөгжил, худалдааны нээлттэй бус байдал нөлөөлж байна гэж үзжээ.

Чен нар (2015) Хятадын зүүн хойд бүсийн компаниудын хөрөнгө оруулалтанд нөлөөлөх НӨАТ-ын нөлөөллийг судлан их хэмжээний бэлэн мөнгөний урсгалтай жижиг компаниуд татварын хөнгөлөлтөд хүчтэй хариу үйлдэл үзүүлдэг гэж дүгнэсэн.

С. Дарьсүрэн (2013) НӨАТ ногдуулах босго хэмжээг нэмэгдүүлэх боломжийг судалсан. Судлаач НӨАТ-ын хуулийн бүтэц, тогтолцоо сайн боловч, бүх салбартаа эрх тэгш үйлчилж чадахгүй байна гэж үзсэн. НӨАТ-ын босгыг зайлшгүй нэмэх шаардлага байгааг тайлбарласан.

П. Пунцаг (2014) НӨАТ төлөгчийн бүртгэл, буцаан олголт, бүртгэл тайлагнал болон хуулийн хэрэгжилт, түүнд тулгамдаж буй асуудлыг судалсан. Судлаач НӨАТ-ын хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэснээр далд эдийн засгийг арилгах, улмаар эдийн засаг дахь төрийн хяналтын тогтолцоог бий болгоно гэж үзсэн.

Б. Авирмэд нар (2016) МУ-ын НӨАТ-ын хуулийн шинэчлэл нь иргэдийн татварын боловсролыг дэмжихэд ач холбогдолтой байсан гэж дүгнэжээ.

Зарим улс орнуудын НӨАТ-ын хэрэгжилтийн байдал

НӨАТ-ыг 1948 онд Францад анх нэвтрүүлж, 1954 онд бөөний худалдаанд, 1968 онд жижиглэнгийн худалдаанд ногдуулснаар хэрэглээний татварын хэлбэрт шилжжээ. Үүний дараагаар Кот'д Ивуар, Сенегал улс болон АНУ-ын Мичиган мужид нэвтрүүлсэн байна. Харин 1960-аад оны сүүлийн хагасаас Бразил, Дани улсад нэвтэрснээр Өмнөд Америк болон Европын орнуудад НӨАТ-ыг хэрэглэж эхэлжээ. Дараа нь Төв Америк, Африк, Ойрхи дорнод болон Ази, Балтик болон социалист орнуудад нэвтэрч эхэлжээ. Дэлхийн II дайны дараагаас нэвтэрч эхэлсэн энэ татвар нь одоогоор дэлхийн 160 гаруй оронд нэвтэрч, жил

Хүснэгт 1. Улс орнуудын НӨАТ-ын эрх зүйн зохицуулалт, урамшууллын систем

Улс орнууд	НӨАТ-ын хувь хэмжээ	НӨАТ-ын хязгаар	Урамшууллын систем
Монгол улс	10%	0-10%	Сугалаа, НӨАТ-ын 20% буцаалт
Тайвань	5%	5%	Сугалаа
Португал	23%	17- 23%	Сугалаа
Польш	23%	22 - 23%	-
Словак	22%	19-22%	Сугалаа
Орос	18%	18%	-
БНХАУ	17%	17%	Сугалаа
Казакстан	12%	12-15%	-
Латви	21%	18-22%	-
Малта	18%	15-18%	Сугалаа

Эх сурвалж: <https://tradingeconomics.com/ireland/sales-tax-rate>

бүр дунджаар татварын орлогын 27 хувь⁵ буюу ДНБ-ий 5 орчим хувьтай тэнцэх хэмжээний орлогыг бүрдүүлж байна. Монгол улс (МУ)-ын НӨАТ-ын хуулийн шинэчлэлээр хэрэглэгч худалдан авалт хийх бүртээ е-баримт авч, баримтаа онлайнд бүртгүүлснээр баримтын дугаараар сугалаанд оролцох, жилийн эцэст төлсөн НӨАТ-ынхаа 20%-ийг буцаан авах боломжтой болсон юм.

Хүснэгт 1-ээс харахад дэлхийн зарим улс оронд НӨАТ-ын урамшууллын системийг сугалаа хэлбэрээр хэрэгжүүлдэг байна.

Монгол улсын НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал

Монгол улс 1998 оны 7 сараас НӨАТ-ыг нэвтрүүлж мөрдөж байгаа бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш өнөөг хүртэл 40 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт орсон хамгийн “тогтворгүй” татварын нэг юм. НӨАТ-ын хувь хэмжээ 1998 оны 08 сарын 28-ны өөрчлөлтөөр 13 хувь, 2000 оны 11 сарын 17-ний өдрийн хуулиар 15 хувь, 2006 оны 06 сарын 29-ний өдрийн хуулийн шинэчилсэн найруулгаар 10 хувь

болж өөрчлөгдсөн.

Манай улсад өмнө нь (2007.01.01-2015.12.31) мөрдөгдөж байсан НӨАТ-ын хууль падааны аргад түшиглэсэн татварын системийг хэрэгжүүлж байсан бол 2016 оноос шинээр хэрэгжсэн НӨАТ-ын хууль нь программжиж, цахим хэлбэрт шилжсэнээрээ онцлог юм. Нэгдсэн системд баримт илгээх, хэвлэх тусгай тоног төхөөрөмж, программ шаардлагатай. Эдгээрийг нийлүүлэгч 22 аж ахуйн нэгж байгаа бөгөөд бизнес эрхлэгч иж бүрнээр нь худалдан авахад эхний удаа 899,000-3,370,000 төгрөг зарцуулдаг байна.

Нийт татвар төлөгчийн тоо, НӨАТ төлөгчийн тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна. Татвар төлөгчдийн дүнд эзлэх НӨАТ төлөгчийн тоо сүүлийн 8 жилд тогтмол 20-24%-ийг эзэлж байгаа юм. 2005-2007 оны хооронд нийт татварын орлогын дүнд эзлэх НӨАТ-ын хувийн жин буурч байгаад 2008 болон 2015 оноос өссөн үзүүлэлттэй байна.

Шинэчилсэн найруулга хэрэгжсэнээр⁶ 2016 онд 38,825 бизнес эрхлэгч

Хүснэгт 2. Бүртгэлтэй татвар төлөгч, НӨАТ төлөгчдийн тоо

Он	НӨАТ суутган төлөгч тоо	Татвар төлөгчид НӨАТ төлөгчийн эзлэх хувь	НӨАТ төлөлт /мян.төг/	Татварын орлогод эзлэх НӨАТ-ын хувь
2005	5,453	18.7%	70,169,658.4	19.9%
2006	5,716	17.2%	88,658,825.3	12.2%
2007	7,509	18.8%	94,601,423.3	8.8%
2008	9,725	20.2%	139,152,889.8	12.0%
2009	11,798	22.6%	157,413,778.2	16.8%
2010	14,236	23.1%	208,085,730.6	13.5%
2011	17,409	23.9%	366,476,752.8	16.5%
2012	19,189	24.4%	497,603,081.8	22.0%
2013	25,576	20.2%	568,016,774.0	20.8%
2014	29,540	20.5%	546,419,586.7	19.4%
2015	31,726	21.2%	482,740,544.3	17.7%
2016	32,462	20.0%	553,200,000.0 ⁷	20.6%

Эх сурвалж: <http://www.mta.mn/page/file>

⁵ http://gst.customs.gov.my/en/gst/Pages/gst_ci.aspx

⁶ www.mta.mn

⁷ Өдрийн сонин, 2017.02.06

бүртгэлийн машин хэрэглэж, мэдээллийг төлбөр тооцооны бүртгэлийн системд илгээж, НӨАТ-ын орлогын хэмжээ 70 орчим тэрбум төгрөгөөр өссөн. Мөн сугалааны урамшуулалд 3.6 тэрбум, 20 хувийн буцаан олголтын урамшуулалд 35.5 тэрбум төгрөгийг буцаан олгосон.

2017 оны эхний 10 сарын байдлаар 3.42 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна.

Судалгааны хэсэг

100 айл барилгын материалын захад нийт 1,116 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг. Эх олонлогийг төлөөлөх түүврийн хэмжээ 89 иргэн, аж ахуй нэгж байна.

$$n = \frac{rZ^2(1-r)N}{Ne^2 + rZ^2(1-r)} = \frac{0.5 * 1.96^2(1-0.5)1116}{1116 * 0.1^2 + 0.5 * 1.96^2(1-0.5)} = 89$$

n – түүврийн хэмжээ,
r – тархалтын хувь,
Z – итгэлцэх түвшний утга,
N – эх олонлогийн хэмжээ,
e – түүврийн алдааны түвшин.

Алдааны түвшин хамгийн бага байлгах үүднээс санамсаргүй түүврийн аргаар 100 айл барилгын материалын захын 145 бизнес эрхлэгчээс ярилцлагын аргаар чанарын судалгаа, 292 үйлчлүүлэгчээс анкетын аргаар тоон судалгаа авсан.

Үйлчлүүлэгчдээс авсан судалгаа

292 үйлчлүүлэгчдээс судалгаа авснаас 61% нь гэр бүлийн хэрэгцээнд зориулан, 24% нь байгууллагын хэрэгцээнд зориулан, 15% нь борлуулах зорилгоор үйлчлүүлдэг байна. Судалгаанд хамрагдагсдын 33% нь 100,000 төгрөгнөөс доош, үлдсэн нь 100,000 төгрөгөөс дээш худалдан авалт хийж, жилд дунджаар 69% нь 10 ба түүнээс доош, 31% нь 10-с дээш удаа тус захаар үйлчлүүлдэг байна.


Судалгаанд хамрагдагсдын 59% нь

худалдан авалтандаа е-баримт огт авдаггүй гэж хариулсан байна.

Хүснэгт 3. Худалдан авалтын үнийн дүн болон баримт олголт

Үнийн дүн (мян.төг)	Баримт олголт			
	Байнга	Ихэвчлэн	Хааяа	Огт авдаггүй
0-30	3	1	6	61
30-100	2	6	22	55
100-500	7	6	24	40
500-с дээш	11	13	17	18
Дүн	23	26	69	174

Зураг 1. Баримт олгоогүй тоо ба худалдан авалтын үнийн дүнгийн хамаарал



Дээрх графикаас харахад худалдан авалтын үнийн дүн бага бол баримт олгох хандлага буурч байна. Хэрэглэгчдээс е-баримт аваагүй шалтгааныг асуухад:

- худалдагч нар өгдөггүй, баримт шаардах төвөгтэй,
- баримт авбал үнийн дүн дээрээ 10%-ийг нэмж төлөхийг шаарддаг,
- е-баримт өгдөг эсэхийг мэдэхгүй гэж хариулжээ.

Е-баримт авдаг үйлчлүүлэгчдийн 23% нь посын машинаас, 27% интернэтээс, 12% нь е-баримтын дундын машинаас авдаг байна.

Нийт хэрэглэгчдийн 59% нь е-баримт авдаггүй гэсэн үр дүн гарч байгаа нь хуулийн хэрэгжилт, хяналт сул байгааг

Хүснэгт 4. Худалдан авалтын зорилго болон е-баримт олголт

Худалдан авалтын зорилго	Е-баримт авдаг (%)	Е-баримт авдаггүй (%)
Байгууллагын хэрэгцээнд	57	43
Борлуулах зорилгоор	27	73
Гэр бүлийн хэрэгцээнд	39	61
Нийт үнийн дүнд эзлэх	41	59


харуулж байна. Байгууллага болон бизнес эрхлэгч иргэн е-баримтаа авахгүй байгаа

нь татвараа нуух, НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэхээс зайлсхийж байгааг харуулж байна.

Бизнес эрхлэгчдээс авсан судалгаа

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 75% нь е-баримтын талаар мэдээлэлтэй, 25% нь мэдээлэлгүй гэж хариулжээ. Е-баримтын талаар мэдээлэлтэй бизнес эрхлэгчдийн 50% нь татварын албанаас, 16% нь найз нөхдөөсөө, 17% нь интернетээс, 17% нь хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авдаг байна.

Зураг 2. Үйл ажиллагаа явуулсан хугацаа ба е-баримт олголтын байдал




Е-баримт олгодоггүй шалтгаан:

- Хэрэглэгч е-баримтаа шаарддаггүй,
- Татварын дарамт үүсгэдэг,
- Хэвлэгч машин байхгүй,
- НӨАТ, е-баримт болон технологийн мэдлэг дутмаг,
- Е-баримт хэвлэх төхөөрөмж үнэтэй,
- Баримт хэвлэхэд цаг хугацаа, интернет шаарддаг зэрэг.

Интернэтээр болон дундын машинаар е-баримт олгодог бизнес эрхлэгчдийн 80% нь баримт олгоход цаг хугацаа их шаарддаг гэж хариулт өгсөн байна.

НӨАТ болон е-баримтын талаарх мэдлэг бүхий бизнес эрхлэгчид е-баримт олгож байгаа нь Зураг 3-аас харагдаж байна.

Зураг 3. Бизнес эрхлэгчдийн мэдлэг болон е-баримт олголтын хамаарал



Дүгнэлт

Улс орон бүр өөрийн онцлогт тохируулан НӨАТ-ыг тодорхой босготой, босгогүй нэг хувь хэмжээтэй байхаас гадна буцаалт хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг өөрийн орны онцлогт тохируулан шийдвэрлэдэг байна. НӨАТ нь дэлхийн 160 гаруй оронд нэвтэрч, жил бүр дунджаар татварын орлогын 27 хувь буюу ДНБ-ий 5 орчим хувьтай тэнцэх хэмжээний орлогыг бүрдүүлж байна.

МУ-ын НӨАТ-ын шинэчилсэн хуулийн дагуу хэрэглэгч худалдан авалт хийх бүртээ e-баримт авч, баримтаа онлайнд бүртгүүлснээр баримтын дугаараар сугалаанд оролцох, жилийн эцэст төлсөн НӨАТ-ынхаа 20%-ийг буцаан авах боломжтой болсон юм. НӨАТ-ын сугалааны урамшууллын системийг Тайвань, Бүгд найрамдах Словак зэрэг улс амжилттай хэрэгжүүлж, эдийн засгийн өгөөжөө нэмэгдүүлсэн байдаг. Монгол улсын хувьд сугалааны урамшууллаас гадна буцаан олголтын урамшууллыг олгож, иргэдэд хуримтлал үүсгэх боломжийг бүрдүүлснээрээ давуу талтай юм. Шинэчилсэн найруулга хэрэгжсэнээр 2016 онд 38,825 бизнес эрхлэгч бүртгэлийн машин хэрэглэж, мэдээлийг төлбөр тооцооны бүртгэлийн системд илгээж, НӨАТ-ын орлогын хэмжээ 70 орчим тэрбум төгрөгөөр өссөн. Мөн сугалааны урамшуулалд 3.6 тэрбум, 20 хувийн буцаан олголтын урамшуулалд 35.5 тэрбум төгрөгийг буцаан олгосон.

“100 айл” барилгын материалын захын 145 бизнес эрхлэгч, 292 үйлчлүүлэгчээс асуулгын аргаар судалгаа авах замаар

e-баримтын хэрэгжилтийг судлахад хэрэглэгчдийн 59% нь худалдан авалтандаа e-баримт огт авдаггүй гэсэн үр дүн гарсан. 292 үйлчлүүлэгчдээс судалгаа авснаас 61% нь гэр бүлийн хэрэгцээнд зориулан, 24% нь байгууллагын хэрэгцээнд зориулан, 15% нь борлуулах зорилгоор үйлчлүүлсэн байна. Судалгаанд хамрагдагсдын 33% нь 100,000 төгрөгнөөс доош, үлдсэн нь 100,000 төгрөгөөс дээш худалдан авалт хийж, жилд дунджаар 69% нь 10 ба түүнээс доош, 31% нь 10-с дээш удаа тус захаар үйлчлүүлжээ. Мөн бизнес эрхлэгчид худалдан авалтын үнийн дүнгээс хамаарч e-баримтыг ялгаатай байдлаар олгодог байна. E-баримт олголт нь хэрэглэгч тухайн барааг байгууллагын хэрэгцээнд, худалдан борлуулах зорилгоор эсвэл гэр ахуйн хэрэгцээнд зориулан худалдан авч байгаагаас үл хамаарч байна.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 75% нь e-баримтын талаар мэдээлэлтэй бөгөөд эдгээр бизнес эрхлэгчдийн 50% нь татварын албанаас, 16% нь найз нөхдөөсөө, 17% нь интернетээс, 17% нь хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авчээ. Бизнес эрхлэгчид хэрэглэгч баримтаа шаарддаггүй; татварын дарамт үүсгэдэг; хэвлэгч машин байхгүй; НӨАТ, e-баримт болон технологийн мэдлэг дутмаг; e-баримт хэвлэх төхөөрөмж үнэтэй; баримт хэвлэхэд цаг хугацаа, интернет шаарддаг зэрэг шалтгаануудаас болж e-баримт олгоогүй гэж хариулсан байна. НӨАТ-ын талаарх хангалттай мэдлэгтэй бизнес эрхлэгчдийн e-баримт олголтын түвшин сайн байна гэсэн үр дүн гарсан.

Санал

- Борлуулагч нэгдсэн системд баримтаа илгээгээгүй байсан ч худалдан авагч талын бүртгэл системд автоматаар бүртгэгддэг болсноор аж ахуйн нэгж орлогоо нуух боломжгүй болно.
- Хэрэглэгч төлбөрийн картаа ашиглан гүйлгээ хийсэн тохиолдолд мэдээлэл автоматаар нэгдсэн системд бүртгэгддэг болсноор цаг хугацаа, зардал хэмнэх боломжтой.
- Зөвхөн е-баримт руу нэвтэрдэг wifi төхөөрөмж захууд дээр байршуулсанаар сүлжээ унах, гацах асуудал багасна.
- Тоног төхөөрөмж, программ худалдан авахад хөнгөлөлт үзүүлснээр бүх аж ахуйн нэгж е-баримтыг хэвлэж өгөх боломжтой болно.
- Татварын албаны сургалт, гарын авлагыг хялбарчлан сайжруулж, татвар төлөгчдөд хүртээмжтэй, тогтмол сургалт явуулснаар мэдлэг нэмэгдэж хуулийн хэрэгжилт сайжирна.
- Татварын боловсролыг ерөнхий боловсрол, их дээд сургуульд заавал судлах хичээл болгон оруулснаар иргэдийн татвар төлөх нийгмийн сэтгэлзүйд эерэгээр нөлөөлөх боломжтой.

Ашигласан материал

1. Chen, Y., He, Z., Zhang, L. (2015). The Effect of Investment Tax Incentives: Evidence from China's Value-Added Tax Reform
2. Ebeke, C., Ehrhart, H. (2011). Is VAT Stabilizing?, Working Paper from CERDI, E2011.24
3. Harrison, G., Krellove, R. (2005). VAT Refunds: A Review of Country Experience, *IMF Working Paper*, WP/05/218
4. Keen, B., Lockwood, B. (2010). The Value Added Tax: Its Causes and Consequences, *Journal of Development Economics*, 92(2), 138-151
5. Авирмэд, Б., Өнөржаргал, Ч. (2016). НӨАТ-ын тухайн хуулийн хэрэгжилтээр дамжуулан татварын боловсролыг дэмжих нь
6. Алтанзаяа, Г. (2016). Татварын бүртгэл
7. Гантулга, Г., Өнөржаргал, Ч. (2010). НӨАТ-ын хуулийн хэрэгжилтэнд тулгамдаж байгаа зарим асуудлууд
8. Дарьсүрэн, С. (2013). НӨАТ ногдуулалтын үндэслэлийг сайжруулах боломж
9. Пунцаг, П. (2014). НӨАТ-ын бүртгэл, тайлагналыг сайжруулах нь
10. Сүхээ, Д. (2015). НӨАТ-ын тухай хуулийн төслийн сул талууд
11. Цогт, О. (2010). НӨАТ-ын хэрэгжилт, цаашдын чиг хандлага
12. www.mta.mn
13. www.legalinfo.mn